

БИЙ БИЕЛЭГИЙГ АМБИВАЛЕНТ ШИНЖЭЭР ТАЙЛБАРЛАХЫН УЧИР

Ч.Болдбаатар, Т.Цэцэгжаргал¹

[БИЙ БИЕЛЭГ] гэх ардын язгуур, нийлэг шинж бүхий зан үйлээс улбаалсан биеэр үйлдэгдэх өвөрмөц гарвал нь эдүгээ бүжгийн урлагийн бие даасан төрөл аймаг болтлоо хөгжжээ. Ийм төрөл аймагт багтах зүйлс Алтайн зах хязгаарын ястны дунд аморф шинжээ өвлөн хадгалж үлдсэнийг олон судлаачид дурьддаг. Аливаа бүжгийн үүсэл гарал, уламжлалыг мөшгөхдөө “урлаг” гэж ойлгохоос өмнөх баларлиг үеийн домог зүйн сэтгэлгээнээс үүтгэн тайлбарлах нь зүйд нийцнэ.

Хэрвээ бид тайлга тахилгыг хүний үйл хөдлөл хийгээд зан үйлийн утгад шилжсэн тэмдэг дохио шиг, бэлгэдэл зөн шиг хүлээж авбаас биелэх гэдгийг мэдэхгүй ямар ч ард түмэн байхгүй нь мэдээж. Нөгөө талаар ад зэтгэрийг даран гэтэлгэх дом шившлэг мэт, сэтгэл засах аргатай хамаатуулж үзвэл биеэр үйлдэгдэх занга дохио бүр аморф гарвалтай нь мэдэгдэнэ. Үүнээс бий биелэгийг амбивалент шинжтэй холбож үзэх хандлага нилээд сонирхол татдаг. Ялангуяа тайлга тахил өргөж, хэмнэл эргэлэгийн таарах таарахгүйг дохиож хэрэглэснийг зөвхөн зан үйлийн утгаар хязгаарлалгүй, бүжих алогик сэтгэмжийн язгуураар шинжин судлах шаардлага нэхэгдэж байгаа юм. Гэхдээ инстинктив (зөн) түлхэцээ гээхээрээ амьдралынхаа уг сурвалжийг алддаг гэж үздэг примитив төсөөллийг анхаарах хэрэгтэй. Түүхч Э.Гомбрихийн “pictures and statues, in other words are used to work magic”² хэмээсэн нь бидний таамаглалыг улам бататгаж байна. Учир юун гэвэл, угсаатны биеэр үйлдэх зан үйл нь эдээр шившихтэй адилдуу амьшиж байсныг онцолж үзэх шаардлага гарч ирнэ.

Иймээс бий биелэгийн морфогенезис гарвал нь тайлга тахилгын үйл холбогдлоос эхтэй тул яг бүжгийн хэлний тогтолцоогоор буюу утгад хөдөлгөөн хувилбарших галбир зохирлоор шууд тайлбарлах боломжгүй. Үүний оронд хүмүүний оршихуйд ихээхэн хамааралтай инстинктив хамгаалал, хүсэмжлэн дуурайх мистик шалтгаанд суурилан ойлговол илүү зохилтой. Яагаад гэвэл, хориг цээрт нуугдмал шинжтэй оршдог бибинар утгалбарт далд хүчийг (эзэн савдаг, сэтэрт амьтан) урьд урьдаас хэтийдэн оноох арга (мистификаци) илүүтэй агуулагддаг юм. Тэгээд ч муу, сайн ёр бэлгээр сэрэгдэх адилсал, зэрэгцэл бүхий ассоциацийн зарчмаар үүдэх мистик төсөөг илтгэх нэгэн зүйлд бидний нягтлаж буй бий биелэгийн амбивалент шинж яригдахад хүрсэн билээ. Тухайлбал, ан авын ёслолд үйлддэг чатга байна. Чатга тавина гэдэгт зөвхөн биелэх агсал шившлэг дангаар агуулагддаггүй, түүнд амьтны амьсүнснийг авран гэтэлгэх болзолт тэмдэг хамтдаа үйлдэгдэх явдал бий. Энэ нь мистик сэтгэмжийн хувиар бол юм ба үйлдэл хоёрыг зэрэг цагжуулан ойлгох, улмаар [ЖИР ЗЭРЭГЦЭЛ-БИ БИНЕР] гэх давталтаас

1. Монгол Улсын Их Сургууль

2. Gombrich E.H. The story of Art-Strange Beginnings, W., 1996, p.18.

үүдэлтэй байх аж.

Үүнийг тайлбарлахын тулд, Льюсен Леви –Брюль хамтын ухамсарлахуйгаар дамжин сүсэг-зан үйлийг сүнстэй холбон тайх үйлдлийг ойлгох боломжтой, гэхдээ бинарчлал нь зөрчлийг үл харгалзах шинжтэйг анхааруулсныг үндэслэл болгох хэрэгтэй. Хамтын ухамсар гэдгийг баларлиг нийгмийн харилцаанд синкретикээр тайлбарладаг дүрс (дом), чимээ (шившлэг), үйлдэл (бий) мэтийн домгийн сэтгэлгээний адил нийтийг хамарсан зүйл гэж ойлгож болно. Ерөөс угсаатны зан заншлын бэлгэдэл тэмдэгтэд биеэр үйлдэх хөдөлгөөний хамтын шинж ихээхэн үүрэгтэй байсан учир баларлиг төрхөөрөө хувь хүн, ганц хүнд хамаатуулах зүйл үгүй байдаг нь хамгийн гол юм. Тэгэхлээр “юмыг” бэлгэдэнэ гэдэгт олшруулахын сацуу зэрэг зэрэг үйлдэх бинарчлал заавал яригдана гэсэн үг. Яг нийм парадокс нь “зэрэг цагжуулах” аморф үүдлийг тодотгох бөгөөд зөн совинтой шууд холбогдож, ухамсаргүй ба ухамсарт хоёрын хамаарлыг хамтад нь хэрэглэх нөхцлийг дагуулах явдлыг үүсгэдэг.

Домогт ч, биелэгийн дохио зангад ч яг дүрэм гэмээр тогтсон зүйл үгүй бөгөөд түүний оронд “хориг дүр” (табу) тэмдэгшдэг гэж ойлгож болох талтай. Энэ утгаараа биелэгийн хөдөлгөөний үндэст нэгж хэсгүүд бүхэл зүйлтэй адил байх буюу “*pars pro toto*” гэх синкретик зарчим үйлчилнэ. Эндээс Э.Кассирерийн ярьдаг домгийн орон, цаг, үйлдэлт төсөөлөл урган гарч тайлбарлагдах ёстой. Нэг ёсондоо онго хийгээд ид шидийг тайх ёсонд “амьдрал ба үхэл” гэсэн эсрэгцэл байдаггүй тул “ургамал”, “амьтан” тус тусын ялгамжгүй, харин ч идэш мэт сэтгэгддэг нь гайхалтай. Иймээс эртний зурлага сүгийн дом шившлэг бүхий үйлдлийг бибинар шинжтэй хэмээн үзэхээс өөр аргагүйд хүрсэн билээ.

Тухайн “бибинар” (зэрэг, зэрэг нөхөгдөх зарчим) зангилаанд хүмүүний удмын хэлхээс үл тасалдах тухай төсөөлөл нэвт шингэдэгээс гадна үхэл-төрөлтийн мөчлөг шиг залгавар зөрчлийг даван гэтэлгэх үйл явц хамтаар оршдог. Энд “юм” ба түүний “нөхцөл” огт яригдалгүй дан ганцхан хүн ба юм хоорондын харилцаан дахь саад тогтор хийгээд өнийн ерөөл л бий. Утгаа эрт баларын онч дохио гэдэг амь зуулгад чухал хэрэгцээтэй бодит үйлдэл байдгаараа онцлог. Тиймээс л эрт цагт хүмүүс зэрлэг араатнаас төдийгүй муу ёрын зүсэн зүйлийн сүнснээс айдас сүүдрээ аврах, ад зэтгэрээс ангижрах гэж дуу чимээгээр шившиж, занга гороо тавих болдог байж л дээ. Ингэх нь ч аргагүй юм. Эдгээр баримтыг зориуд дурдсаны шалтгаан нь үгээр хэлж эс болох зөвхөн биеэр үйлдэж гороолох бараг л пантомимо шиг сакраль дохио занга энд яригдах болсноос тэр. Бий биелэгийг утгачилах аргагүй аморф давхцалыг илэрхийлэх хамтын үл ухамсарлахуйн үүдэл, синкретик тогтолцоонд хамаатуулж ойлгож болох мэт санагдана. Тэгэхлээр тэс өөр хоёр зүйлийг төслөг шинжээр өөр хооронд нь зэрэгцүүлэн байршуулж, нэгийг нөгөөгийн орлуулга болгон сэтэрлэж буйг биеэлбэр үзэгдэл гэж ойлгож болох талтай. Үүнд Клод Леви-Стросын ярьдаг менталь бүтэц, Мишель Фукогийн тавьсан дискурсив боломж гэх ойлголт, Зигмунд Фройдын табугаас гадна бусад судлаачдын хөндсөн, ялангуяа баларлиг зан үйлийн амбивалент шинжийн тухай тайлбар нь бидний судалж буй асуудлыг нягталж мөшгөхөд онолын баттай үндэслэгээ болж өгөв.

Биеэлбэрийн дохио зангыг түүнд харгалзах амбивалент дүр буюу домогзүйн ухагдахуунаар тайлбарлууштай. Жишээ нь, ураг төрлийн (цусан) холбоог энгийн зурлага, биеэлбэрээр оноох явдал эртний зан үйлд элбэг байж. Үүний баримтыг хадан зурлагын тэмдэглэгээнээс ажиглаж болох байна. Нар сар, бүргэд шонхорыг дээдлэн эрхэмлэдэг ёс үйлдэлд тухайн амирлал зайлшгүй хүчин болдог нь ч учиртай. Түүгээр ч үл барам эрхсийн тэмдэг нь зөвхөн уул усны эздийг аргадах үйл зорилгоос шалтгаалан догтроо мөн олон янз болж байна. Адаглаад, үхэр сарын адаг, бар сарын эхэнд ад зэтгэрийг зайлуулахдаа заавал аливаа нэгэн амьтныг золигт гаргадаг ёс буй. Зурагдсан шувуун дүрс нь бөө мөргөлийн түлхүүр тэмдгээр бол нар, сүнс, өр (газар) элч гэсэн давхар давхар утга болой. Мөн шувуу, хүний дүрсээр өөрсдийн онго сүлдийг сахиулсан гэж тайлбарлах явдал ч байдаг. Тиймээс л сахиулсан зүйлсээ тахин шүтдэг шувуунд (бүргэд) давхар даатгасан³ гэж нь ч бий. Бидний мөшгөсөн баримтаар, солонгосын

3 Дорж Д. “Монголын хүрлийн үеийн хадны зураг”-Эртний судлал, угсаатны зүйн бүтээл, УБ., 1963, 9-р тал,

бөө мөргөлийн Сандэ Кү гэдэг багт бүжгийн төрөл болох Талчүм хэмээхэд бас л тийм дохио зангыг үйлдэн тойрон бүждэг. Энэхүү Талчүм жилд тогтмол өдөрт овог аймгийнхний төлөө, ус билчээрийн төлөө, муу муухайг зайлуулах үйлийн ёгтлол болж хэрэглэгддэг. Хамгийн сонирхууштай нь хөлөөр дэвсэн харайлж байгаа тэр хөдөлгөөн болно. Гараа дээш алдлан, хөлөөрөө газар дэвслэн тойрч шавах шиг хөдөлгөөн манай орны Их Тэнгэр болон бусад хадны зурлагад нэгэн адил байгаа нь анхаарагдана. Бүр хүрэл зэвсгийн дунд үед ийм шүтлэгийн хэлбэр манайд байсан бөгөөд хоёрдугаар сарын гурав дахь өдөр энэ ёс үйлийг гүйцэтгэдэг байж. Нөгөө талаар, хоёрдугаар сарын гурван гэдэг нь хуучны тооллоор өвлийн сүүл сарын 29-ний өдөр бололтой. Үхэр сарын сайн давсныг бэлгэдэхийн ерөөл нь жилийн өнгөнд ад зэтгэрийг даран арилгаж, угтах улирлын сайн сайхныг урин дуудахаас үүдэлтэй гэж үздэг ба ингэхдээ заавал үхрийг домносон сүг зурлагыг дагуулах юмуу, өргөдөг тал бий. Үүнээс үзвэл, бөө мөргөлд төдийгүй түүнээс өмнөх тайлга тахилгын дом шившлэгт гараа өргөн уухайлах, газар дэвсэн цамнах явдал байсныг гэрчилээд зогсохгүй МЭӨ 1200-700 жилийн тэртээ занга жатга тавих зан үйлийн бүжиг хэдийнээ байсныг давхар хэлэх мэт. Энэ нь хожмоо ураг тариг барилдах зан үйлийн бүжигт уламжлагдсаныг “Басганы их наадаан” бэлхнээ харуулна. Буриадын заншилд буй “Басганы их наадаан” нь гэрлэх зан үйл хийгээд дуут бүжиг наадааны цогц болохынхоо хувьд “...орон дэлхийн эзэд, овоо уулын савдаг, ус лусын эзэд, онгод тэнгэр нар хотлоор баясаж, хоймрын хор, хотны тоггорыг тонилгож, залуусын хийморь цог золбоог бадраадаг”³ тул ийн үйлддэг аж. Ингэж дуулж бүжихийг хамтатган бөөлөх гэдэг тал ч бас бий ажээ.

Хаданд “хий сүг” босгох нэг хэрэг, харин түүнийг шившиж биеэр занга тавьж ёслох нь өөр зүйл гэж ойлгож огт болохгүй. Яагаад гэвэл, шившлэг үгүйгээр, сүг үгүйгээр бий [БИЕЛЭГ БИШ] болно. Биелэгийг амьшуулахад шившлэг, жатга, үйлдэл, занга оролцохгүй бол хоосон тэмдэг хэвээр үлдэнэ. Тахилч жатгачдын энд тэндгүй домнодог байсан шид хөгжөөх шинжтэй зан үйл дотор хар элгэтнийг төлөөлүүлэн сүг үйлдээд цээжийг нь нэвт сүлбэх юмуу, шатаах явдал бий. Ийм үйлдлээр хар элгэтнийг хороож, [ХОР ХӨНӨӨЛ] учруулаад зогсохгүй элгэтний санааг эргүүлж болно гэж үздэг байжээ. Хожмоо сор залах, золигт гаргах гээд бас л шатаадаг байсан. Манайхны заншлаас тэрхүү шатаан золидог ёсны ул мөр огт салалгүй бараг өдгөөтэй золгосон байх юм.

Мистик сэтгэлгээний нууцлиг орчин руу орох тусам [ШИДЭЭР ЗАСАХ] үйл юутай холбоотой, яагаад синкретикээр үйлдэгдэх ёстойг бага сага гадарлахад хүрдэг. Тухайлбал, ан авын олз омог нь болох ёстой байдалтайгаа заавал дүйх шаардлагатайгаас л оноох амьтдаа сүлбэж, урьдаас авахаар аргадан тохирвол (дүрслэвэл) цаад зүйлээ эрхэндээ оруулаа хэмээн балрын гөрөөчид ухамсарладаг байж л дээ. Одоо ч гэсэн дом [БИЙ БИЕЛЭГ] үйлдэн сүнсийг тахиx явдал хаа нэгтээ байсаар буй. Судлаачдын тэмдэглэсэн⁵ Хүрээ хошууны болон Монголжины овог аймгийн дунд байдаг, бага залуу эмсийн өвчнийг засах [АНДАЙ ДЭВСЭЛ] хэмээх зан үйлийн бүжгийг энд жишээ тагаж болно. Дэвсэл бүжгийн талаархи мэдээллийг нягтлан үзвэл, эртнээс [УД МОД] тайх, галын ёслол буюу уул усны эзнээ аргадан хөгжөөж, бүл олноороо үйлдэхийн учир холбогдолтой зан үйлийн улбаа болох нь тодорч харагдана.

Чухамдаа бий биелэгт хүмүүний сүлд хийморийг даллаж дуудах, хөдлөл суудлыг болон зам мөрийг засаж гэтэлгэх, аливаа ад зэтгэрээс түр боловч ангижрах хүсэмжлэл дагалддаг. Бөө мөргөлийн ёсоор бол хүний сүлд зайлвал бүсийг нь тайлан, хэт цахиурыг цахиж бөөлөөд сүлдийг эргүүлэх ёстой. Энэчлэн сүлдээ тайж тахиx уламжлалд онго тэргүүтнээ сүнс хэмээх ухагдахуунтай нэгтгэн холбож үздэг байна. Онго сүлдээ тайгчийг бөө буюу [БҮГҮ] хэмээнэ. Задалж тайлбарлавал, эртний түрэгийн [БҮГҮ] гэх үг “мэргэн төлөгч” гэсэн утга илэрхийлдэг бол, эртний түрэг хэлний [БҮ-ДИК] гэх үг шид хөөх буюу хөдөлгөөний хүч чадлаар золигт

3. Гантогтох Г. “Монгол зан үйлийн аман яруу найргийн уламжлал”, УБ., 2007, 69-р тал.

5. Дулам С. Монгол бэлгэдэл зүй III, УБ., 2007, 213-р тал.

гаргах ёслолыг заадаг. Харин бүдик гэх үгийн хувилбарыг Э.Севертяны этимологи толиноос⁶ нягтлан үзвэл хожмоо [БИЙ БИЕЛЭГ] хэмээн киргиз хэлнээ тогтож, улмаар манайхны хотон нарт уламжлагдан үлдсэн байх юм. Жишээлбэл, баруун монголд одоо хүртэл гараа хумиж, бүсэлхийг тойруулан, мөрөө хаялж, гараа сацлан биелэдэг нь үүний ул мөр бөгөөд гар хөлөө зөрүүлж хөдөлгөдөгт ч утга магад өгүүлэгдэнэ. Ийм цацал биелэг байгалиа төдийгүй овог бүлгийн сүр сүлдээ тайхаас эхтэйгээс дөрвөн тал, найман зовхистоо мөргөж заншжээ.

Эдгээр баримтаас үзвэл, амбивалент харилцаагаар орших давхацмал утгалбарын тайлал нь бий биелэгийн дохио зангын тэмдэглэлд нэгэн адил хамаатай байна. Үүнийг монгол бий биелэгт удамшсан моноэлементлиг шинж, дан хөдөлгөөн, алогик дохионоос дам үүсэлтэй мистик гарвал бүтцээс ажиглаж болно. Мистик шалтгаалцал байхгүйгээр үйл үйлдэл бүтэх ч үгүй, хэлмэрийн далд дохио шилжих ч үгүй юм. Давхацмал байрших юм ба үйлдлийн зэрэгцсэн утгалбар нь түүнтэй адил орших нөгөө юмыг заахын дээр бас үйлдэлшүүлдэг. Энэ мэтээр бибинар тэмдэг зөвхөн далд юмыг заах биш, амбивалент шинжээр илэрдэг гэдэг нь ойлгогдож байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Гантогтох Г. Монгол зан үйлийн аман яруу найргийн уламжлал, УБ., 2007.
2. Далай Ч. Монголын бөө мөргөлийн товч түүх-ШУАТХ, УБ., 2009.
3. Дорж Д. Монголын хүрлийн үеийн хадны зураг-Эртний судлал, угсаатны зүйн бүтээл. УБ., 1963.
4. Дулам С. Монгол бэлгэдэл зүй III, УБ., 2007, 213-р тал.
5. Сономцэрэн Л. Монголын эртний соёл урлаг, УБ., 1989.
6. Фрейзер Ж.Ж. Алтан гишүү, УБ., 2011.
7. Древнетюркский словарь. Л., «Наука», Ленинградское отделение. 1969.
8. Окладников А.П. О датировке Забайгальских писаниц-Записки БМНИИК. вып XVI.
9. Севертян Э.В. Этимологический словарь тюркских языков. М., 1978.
10. Gombrich E.H. The story of Art-Strange Beginnings. W., 1996.

RESUME

De l'explication du caractire ambivalent de la danse bi biyelgee

Dans le terme « ambivalent » il y a l'idée d'une opposition binaire qui n'apparaot pas réellement dans le texte. Par contre on pourrait parler de faisceau d'éléments gestuels, plastiques en relation avec une mystique non explicitement exprimée, mais qui renvoie a un contexte mythologique dans lequel s'exprime le chamanisme.

Ne pas oublier que, selon les anciens Grecs, les oiseaux ont pu être considérés comme des messagers des dieux. Il n'est donc pas anodin de danser des mouvements figuratifs du vol d'un oiseau. Dans le cas mongol, le vol de l'oiseau est a rapprocher de Garuda (Hangard) de la mythologie hindouiste et bouddhiste.

6. Севертян Э.В. Этимологический словарь тюркских языков. М., 1978. с 131-133